



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 03

Мөрөн

“Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан” ОНӨХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, 77 дугаар хуулийн 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан” ОНӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд төрийг төлөөлж оролцох гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Ж.Ганболд - аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- М.Үүрийнбаяр - аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Ч.Лхагвамядаг - аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Ч.Хадбаатар - аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
- Ц.Буяннэмэх - аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч
- Б.Эрдэнэбилэг-аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. “Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах хүмүүсийг томилсугай.

- Б.Янжиндулам – Мөрөн сумын иргэн
- Ц.Нармандах- аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч
- н.Туяахүү- аймгийн Эмийн холбооны тэргүүн

3. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны дотор хуралдуулж, зөвлөн тусалж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Компанийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

010648